



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

**“ДОРНОД НАА” ОНӨААТҮГ-ЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН
/ДОА-2018-02-ГА/**



“ ДОРНОД НАА” ОНӨААТҮГ-ын Гүйцэтгэх захирал аймгийн Засаг даргатай менежментийн гэрээ байгуулж, дүгнүүлээгүй байна.

Чойбалсан хот

2018 он

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын алба

Дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор Б.Болортуул
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер
В.Цэнгэлмаа
Утас: 70584204

Ахлах аудитор
Б.Дэлгэрмаа
Утас: 70584207

Аудитор
М.Ухаанбилэг,
Я.Зориг

2018 оны 09 дүгээр сарын 28

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584204 дугаарын утас,
dornod@audit.gov.mn
албан мэйл хаягаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р
байр, 2 давхар 04 тоот

I Бүлэг. “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын бүтэц, зохион байгуулалт болон орон нутгийн удирдлагаас тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

1.1. Зохион байгуулалтын бүтэц нь ТУЗ-ийн баталсан бүтэц, орон тоотой уялдаагүй байна.

1.2. Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, дүгнүүлээгүй байхад ТУЗ-өөс үйл ажиллагааг нь хангалттай гэж дүгнэсэн байна.

1.3. Үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

1.4. ТУЗ нь хууль, дүрэм журамд заасныг баримтлан ажиллаагүй байна.

II Бүлэг. “Дорнод НАА” ОНӨААТҮГ нь орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, арвилан хэмнэлтгүй зардлууд гаргасан байна.

2.1. Үйл ажиллагааны орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байна.

2.2. Төлөвлөсөн зардлыг нийт дүнгээр хэмнэсэн боловч арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зардлууд гарсан байна.

2.3. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас авах он дамжсан авлагыг барагдуулж ажиллаагүй байна.

III Бүлэг. Хөрөнгийн худалдан авалт хууль, журмын дагуу явагдаагүй байна.

3.1. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

3.2. “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн худалдан авалтын төлөвлөгөө боловсруулсан эсэх нь тодорхойгүй байна.

3.3. Хөрөнгийн ашиглалт үр дүнтэй байна.

ДҮГНЭЛТ
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ
САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР
ЗӨВЛӨМЖ
ТӨЛБӨРИЙН АКТ
АЛБАН ШААРДЛАГА
ТУШААЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|--------------------|---|
| МУ | Монгол Улс |
| УИХ | Улсын Их хурал |
| ЗГ | Засгийн газар |
| ГА | Гүйцэтгэлийн аудит |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ДОА | Дорнод аймаг |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| НАА | Нийтийн аж ахуй |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ААН | Аж ахуйн нэгж |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ЭМ | Эрүүл мэнд |
| ТБОНӨХБАУХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2018 оны А/06 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасны дагуу Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүгнэлт өгч, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудит хийлээ.

- "Дорнод НАА" ОНӨААТҮГ нь бүтэц, орон тоогоо оновчтой зохион байгуулж, дэвшүүлсэн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх,
- "Дорнод НАА" ОНӨААТҮГ нь орлого, зардлаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байгаа эсэх,
- Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт үр нөлөөтэй байгаа эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын 2017 он, 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө тайлан, худалдан авалт, дотоод болон хөндлөнгийн хяналт хийсэн тайлан, ТУЗ-ийн шийдвэр, тогтоол, захирлын тушаал, бусад холбогдох баримт, материалд тулгуурлан гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл:

“Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ нь 2017 онд 525 аж ахуйн нэгж байгууллага болон орон сууцны 13033, гэр хорооллын 30000 орчим оршин суугчдад цэвэр усны 63,3 км, бохир усны 25,1 км, орон сууцны дулаан, халуун, хүйтэн усны 62 км шугам сүлжээ, дулаан дамжуулах 8 төвөөр дамжуулан халуун, хүйтэн ус, дулаанаар хангах, гарсан бохир шингэнийг татан зайлуулан үйлчилгээ үзүүлэн ажиллажээ.

2017 онд 174 ажиллагсадтайгаар 2395,6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн, 2358,8 сая төгрөгийн зардал гарган 36,8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

2018 оны эхний хагас жилд 169 ажиллагсадтайгаар 1236,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, 1348,6 сая төгрөгийн зардал гаргаж 111,7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журам, гарын авлагад заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, шалгагдагч байгууллагаас авсан

судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, баримтаас хөөн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Холбогдох бусад хууль, журам, хууль эрхийн актууд

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор М.Ухаанбилэг, Я.Зориг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2018 оны 08 дугаар сарын 09-ний өдөр эхэлж 09 дүгээр сарын 28-ны өдөр дуусган дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлууллаа.

Бүлэг I. “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын бүтэц, зохион байгуулалт болон орон нутгийн удирдлагаас тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.


1.1. Зохион байгуулалтын бүтэц нь ТУЗ-ийн баталсан бүтэц, орон тоотой уялдаагүй байна.

1. ТУЗ-ийн 2017 оны 11 дүгээр тогтоолоор 2018 оны бүтэц, орон тоог Захиргаа удирдлага, Санхүү аж ахуй, Цэвэр ус хангамжийн алба, Гэр хорооллын ус хангамжийн алба, Ариутгах татуургын алба, Техникийн шуурхай үйлчилгээний тасаг, Борлуулалтын алба, Инженер, диспетчерийн хэсэг, Ус, дулаан дамжуулан түгээх үйлчилгээний алба гэсэн 9 нэгжтэй байхаар баталсан байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын 2018 оны зохион байгуулалтын бүтцийг гүйцэтгэх захирлын А/03 дугаар тушаалаар бүтцийг босоо хэлбэрээр буюу дараах

байдлаар зохион байгуулсан байна.

Схем №1. “Дорнод Нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц



Эх сурвалж: Гүйцэтгэх захирлын 2018 оны А/03 дугаар тушаалын хавсралт.

Дээрх бүтцээс харахад зарим алба, нэгжийн зохион байгуулалт нь тодорхойгүй байна. Гэтэл гүйцэтгэх захирлын баталсан зохион байгуулалтын бүтцэд Захиргаа удирдлага, Санхүү аж ахуй, Борлуулалтын алба нь тодорхой ялгарч харагдахгүй байна.

Иймд бүтэц, орон тоог удирдлага, зохион байгуулалттай уялдуулж зохион байгуулан хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд ойлгомжтой байдлаар боловсруулах нь зүйтэй байна.

2. ТУЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ыг 185 хүний орон тоотой байхаар баталсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18.5¹-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын бүтэц, орон тооны нормативыг тогтоосон дүрэм, журам, стандарт улсын болон орон нутгийн хэмжээнд батлагдан гараагүй байна.

Тус газрын сүүлийн 3 жилийн орон тооны өөрчлөлтийг судлахад дараах

¹ 5. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны нормативыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

байдалтай байна.

Хүснэгт №1. “Орон тооны харьцуулсан судалгаа”

| Алба, хэсэг | 2018 | | 2017 | | 2016 | |
|--|------------|------------|------------|------------|------------|------------|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| ТУЗ | 8 | 7 | 8 | 7 | 8 | 7 |
| Захиргаа удирдлага | 8 | 7 | 8 | 8 | 8 | 8 |
| Санхүү аж ахуй | 8 | 6 | 8 | 6 | 8 | 6 |
| Цэвэр ус хангамжийн алба | 27 | 25 | 27 | 27 | 26 | 25 |
| Гэр хорооллын ус хангамжийн алба | 38 | 38 | 37 | 37 | 36 | 36 |
| Ариутгах татуургын алба | 14 | 12 | 14 | 12 | 13 | 11 |
| Техникийн шуурхай үйлчилгээний тасаг | 17 | 15 | 17 | 15 | 18 | 16 |
| Борлуулалтын алба | 19 | 18 | 17 | 17 | 17 | 16 |
| Инженер, диспетчерийн хэсэг | 5 | 5 | - | - | - | - |
| Ус, дулаан дамжуулан түгээх үйлчилгээний алба | 41 | 36 | 46 | 41 | 45 | 42 |
| ДҮН | 185 | 169 | 182 | 170 | 179 | 167 |

Эх сурвалж: ТУЗ-ийн 2015 оны 20, 2016 оны 13, 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралт, хүний нөөцийн судалгаа 2016-2018.

Судалгаагаар харахад 2016-2018 онд ус, дамжуулан түгээх үйлчилгээний албанд сантехникийн слесарь 3-5, ариутгах татуургын албанд бохир усны лаборант химич 1, оператор 1, цэвэр усны хангамжийн албанд кипавтоматикийн инженер 1, цэвэр усны худгийн машинч 1 тус тус дутуу явж байна.

Эдгээр орон тоонд ажилтан дутуу байгаа нь тухайн албадын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж байна. Тухайлбал: бохир усны лаборант химич байхгүйгээс байгальд гадагшлуулж буй усны найрлагад тогтмол шинжилгээ хийхгүй байх, мөн сантехникийн слесарь дутагдалтайгаас 1 слесарьд 9 орон сууц оногдож байгаа нь ажлын ачаалал ихсэх, иргэд, аж ахуйн нэгжүүдийн дуудлага, засвар үйлчилгээг цаг тухайд нь гүйцэтгэж чадахгүй байх нөхцөл байдалд хүрсэн байна.

Тус газрын ажилчдаас 2018 онд ажлаас чөлөөлөгдөх 10 хүсэлт ирж шийдвэрлэгдсэн нь шилжилт хөдөлгөөн багагүй байгааг харуулж байна.

1.2. Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, дүгнүүлээгүй байхад ТУЗ-өөс үйл ажиллагааг нь хангалттай гэж дүгнэсэн байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын ТУЗ нь тус компаний 2017 оны үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсэн байна.

Гэтэл тус газрын үйл ажиллагааг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилтээр үнэлж дүгнэсэн талаарх баримт, материал байхгүй байна. Ажил дүгнэсэн тухай ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд 2017 оны үйл ажиллагааг ашигтай, аваар осолгүй ажилласан гэсэн үзүүлэлтүүдээр хангалттай гэж дүгнэсэн бол өмнөх оны үйл ажиллагааг аваарын нөөц бүрдүүлж, өр авлага багасгахад анхаарч, өвөлжилтийн бэлтгэл хангасан гэсэн үзүүлэлтүүдээр мөн хангалттай гэсэн үнэлгээг өгсөн байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 19.1 болон 20.3 дахь

хэсэгт гүйцэтгэх захирал нь томилсон албан тушаалтан буюу аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллахаар заасан байна.

ТУЗ нь гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг дүгнэхдээ хариуцлагын гэрээ болон “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын дүрмийн 8.2² дахь заалтуудын дагуу Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг харгалзах ёстой байна.

Гүйцэтгэх захирал нь аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, биелэлтийг дүгнүүлээгүй байхад 2017, 2018 онуудад өмнөх онуудын ажлыг ТУЗ-өөс хангалттай гэж дүгнэсэн нь дээрх заалтуудтай нийцэхгүй байна.

Аудитын явцад дээрх төлөвлөгөөний биелэлтийг тайлан болон холбогдох нотлох баримтуудыг үндэслэн үнэлж дүгнэлээ.

Тус газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 бүлгийн нийт 87 ажил (үүнд: хөрөнгө оруулалт, их засвар, өвлийн бэлтгэлийн чиглэлээр-36, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, сургалтын чиглэлээр-18, ажилтнуудын нийгмийн асуудлыг дээшлүүлэх чиглэлээр-17, ажлын зохион байгуулалт, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр-16)-ыг хэрэгжүүлэхээр ТУЗ-ийн тогтоолоор батлуулсан байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан 87 ажлаас давхардсан 4 ажлыг хасаж дүгнэхэд 66 ажлыг гүйцэтгэж, төлөвлөгөөний биелэлт 79,5 хувьтай байна.

1.3 Үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын дүрмийн 10.1-д хяналтын тогтолцоог өмчлөгчийн хяналт /МХГ/, хөндлөнгийн хяналт /Төрийн аудит/, дотоод хяналт /аймгийн ИТХ, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар/ гэсэн бүтцээр хэрэгжүүлэхээр заажээ.


1. Дотоод хяналт: МУ-ын ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор 2012 онд захирлын тушаалаар Дотоод хяналт шалгалтын нэгж байгуулсан ч 2017 оны 10 дугаар сараас 2018 оны 09 дүгээр сар хүртэл дотоод хяналтын ажилтангүй байна.

Дотоод хяналт шалгалтын 2017 оны төлөвлөгөөг гүйцэтгэх захирлаар батлуулж, нийт 5 зорилтын хүрээнд 18 ажлыг төлөвлөсөн ч ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж дүгнүүлээгүй, ямар ажил зохион байгуулж тайлагнасан нь тодорхойгүй байна.

Аудитын явцад иргэд, байгууллага, ажилчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга, шийдвэрлэлтийн байдалд дараах шинжилгээг хийлээ.


Дүрслэл №1. “Өргөдөл, гомдлын бүтэц, агуулгад хийсэн шинжилгээ-1”

2. Гүйцэтгэх захирал нь аймгийн Засаг дарга, ТУЗ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд аймгийн Засаг дарга, ТУЗ-ийг төлөөлж түүний дарга нарын гарын үсэг зурна. Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.



Ажилтнуудын ёс зүй, засвар үйлчилгээтэй холбоотой гомдлууд өссөн байгаа бөгөөд амралт, чөлөө авах болон албан тушаал өөрчлүүлэх хүсэлтүүд ч мөн өссөн байна.

Дүрслэл №2. “Өргөдөл, гомдлын бүтэц, агуулгад хийсэн шинжилгээ-2”



Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол 2016-2017 онуудад буурсан үзүүлэлттэй байгаа бол дотроос буюу ажилчдаас ирэх өргөдөл, гомдол 2018 онд өсөх хандлагатай байна.

Энэ нь удирдлага зохион байгуулалт, дотоод хяналтыг сайжруулах асуудалд анхаарах шаардлага байгааг харуулж байна.

Нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлт нь 97-98 хувьтай байна. 2018 онд шийдвэрлэгдээгүй үлдсэн болон шийдвэрлэж хариу өгсөн нь тодорхойгүй 6 өргөдөл байна.

2. Өмчлөгчийн хяналт:

Газрын дүрэмд өмчлөгчийн хяналтыг Мэргэжлийн хяналтын газраас хийхээр

тусгасан бөгөөд тус газраас 2017 онд 3 асуудлын хүрээнд буюу байгаль орчин, хэмжил зүй, эрчим хүчний хяналтын чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулж, 12 заалт бүхий 1 албан шаардлага өгч, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

3. Хөндлөнгийн хяналт:

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас жил бүр тус газрын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж өгч ажиллаж байна.

4. Бусад хяналт:

1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2017 онд 3 асуудлын хүрээнд хяналт шалгалтыг хийж, 2 акт, 2 албан шаардлага өгсөн байна. 2018 оны 09 дүгээр сарын байдлаар акт, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 17.2.1³, 17.2.2⁴ дахь хэсэгт аймгийн ИТХ-ын бүрэн эрхийг зааж өгсөн бөгөөд ИТХ-аас “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгасан талаарх дүгнэлт гаргасан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

1.4. ТУЗ нь хууль, дүрэм журамд заасныг баримтлан ажиллаагүй байна.

1. ТУЗ-ийн гишүүдийг 2015, 2016 онуудад аймгийн Засаг даргын санал болгосноор Дорнод аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор шинэчлэн томилсон байна.

ИТХ нь гишүүдийг томилохдоо хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбоотой Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.4, Засаг даргын бүрэн эрхтэй холбоотой 78.2.3 дахь заалтуудыг үндэслэсэн нь ТУЗ-ийг томилох асуудалтай хамааралгүй байна.

Компанийн тухай хуулийн 75.4-д ТУЗ нь 9 буюу түүнээс дээш гишүүнтэй, мөн тэдгээрийн 1/3 нь хараат бус гишүүн байхаар заажээ. Гэтэл “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын ТУЗ нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй, хараат бус гишүүнийг томилоогүй байна.

Компанийн тухай хуулийн 79.3-т зааснаар хараат бус гишүүний нэмэлт үүрэг, ач холбогдлыг дараах байдлаар заасан байна. Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг /аймгийн ИТХ/ хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;
- Компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
- Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авалтын талаар санал боловсруулах;
- Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ

³ 1/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;

⁴ 2/ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;

худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн зарчимд нийцүүлэн үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих.

ТУЗ-ийн хараат бус гишүүний хяналтын чиг үүрэг нь тус газрын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд ихээхэн чухал үүрэгтэй байна.

2. ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76.1.11, дүрмийн 7.3.6 дахь заалтуудын дагуу “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг ИТХ-д танилцуулж, батлуулах бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3. Аймгийн ИТХ-ын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна гэж дүрэмд заасан байна. ТУЗ нь 2017 онд 4, 2018 онд 1 удаа хуралдсан нь Компанийн тухай хуулийн 80.1⁵ дэх заалттай нийцэхгүй байна.

4. ТУЗ-ийн 2017 оны 01 дүгээр тогтоол, 2018 оны 02 дугаар тогтоолоор “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын 2016, 2017 оны үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэхдээ үйл ажиллагааг бүхэлд нь биш 2-3 үзүүлэлтийг авч үзсэн байна.

Мөн ТУЗ-ийн хурлаар гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг дүгнэж, урамшуулал олгож байгаа боловч албан хаагчид, удирдлагын хариуцлагын асуудлыг авч хэлэлцэхгүй байгаа нь цаашид тухайн төрлийн алдаа дутагдал давтан гарах эрсдэлийг бий болгож байна.

Иймд цаашид ТУЗ нь үйл ажиллагаандаа дээрх хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэн, “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын орлогыг нэмэгдүүлэх, өртөг зардлыг багасгах, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Бүлэг II. “Дорнод НАА” ОНӨААТҮГ нь орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, арвилан хэмнэлтгүй зардлууд гаргасан байна.

2.1. Үйл ажиллагааны орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ нь нийт орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэл, хэрэглээний дунджийг үндэслэн төлөвлөдөг байна. Нийт орлогыг 2017 онд 2390,3 сая төгрөг, 2018 онд 2559,1 сая төгрөгөөр төлөвлөж Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан байна. 2017 онд нийт орлогыг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэлээс 1,4 хувь, 2018 онд 6,8 хувиар тус тус өсгөж төлөвлөсөн байна. Үүнд: Үйл ажиллагааны бус орлогыг өсгөж төлөвлөсөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт №2 “Орлогын судалгаа” /сая.төг/

| № | Үзүүлэлт | 2018 он төлөв- лөгөө | 2017 он төлөв- лөгөө | 2017 он гүйцэт- гэл | 2016 он төлөв- лөгөө | 2016 он гүйцэт- гэл |
|---|--|----------------------------|----------------------------|---------------------------|----------------------------|---------------------------|
| 1 | ААН-ийн дулаан дамжуулах үйлчилгээ | 134,4 | 134,4 | 129,9 | 115,0 | 135,0 |
| 2 | Айл, өрхийн дулаан дамжуулах үйлчилгээ | 153,8 | 153,8 | 159,7 | 146,3 | 152,5 |
| 3 | Халуун ус дамжуулан түгээх үйлчилгээ | 65,5 | 65,5 | 66,3 | 57,5 | 65,0 |
| 4 | Дулааны суурь хураамж | 53,9 | 53,9 | 52,6 | 52,4 | 53,8 |
| 5 | ААН-ийн цэвэр ус түгээх үйлчилгээ | 464,6 | 464,6 | 437,5 | 451,4 | 458,0 |

⁵ 80.1.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно.

| | | | | | | |
|----|--|---------------|---------------|---------------|---------------|---------------|
| 6 | Айл, өрхийн цэвэр ус түгээх үйлчилгээ | 325,6 | 335,9 | 319,9 | 343,4 | 302,7 |
| 7 | Гэр хороололд цэвэр ус түгээх үйлчилгээ | 78,7 | 78,7 | 72,8 | 72,0 | 108,2 |
| 8 | ААН-ийн усны суурь хураамж | 52,4 | 42,5 | 43,7 | 41,3 | 43,9 |
| 9 | Айл, өрхийн усны суурь хураамж | 119,5 | 124,7 | 129,2 | 117,6 | 119,5 |
| 10 | ААН-ийн бохир ус татан зайлуулах үйлчилгээ | 481,7 | 481,7 | 444,2 | 445,7 | 469,8 |
| 11 | Айл, өрхийн бохир ус татан зайлуулах үйлчилгээ | 290,8 | 302,3 | 284,0 | 309 | 268,9 |
| 12 | Хог тээврийн үйлчилгээ | 34,8 | 34,8 | 42,5 | 34,8 | 38,6 |
| 13 | Сантехникийн засвар үйлчилгээ | 18,0 | 18,0 | 22,3 | 12,0 | 24,9 |
| 14 | Бусад | 2,2 | 2,2 | 42,0 | 2,4 | 19,0 |
| | Үйл ажиллагааны орлогын дүн | 2275,9 | 2293,0 | 2246,6 | 2200,8 | 2259,8 |
| 1 | Техник ашиглалтын орлого | 0,0 | 0,0 | 20,5 | 0,0 | 4,1 |
| 2 | Хүү, торгуулийн орлого | 60,0 | 35,0 | 62,4 | 35,0 | 61,4 |
| 3 | Засвар үйлчилгээний орлого | 138,9 | 8,0 | 0,0 | 8,0 | 6,3 |
| 4 | Түрээс | 9,3 | 9,3 | 10,5 | 8,0 | 10,5 |
| 5 | Тендрийн ажил | 0,0 | 0,0 | 5,8 | 0,0 | 0,0 |
| 6 | Бусад | 15 | 15 | 19,8 | 0,0 | 15,3 |
| 7 | Зөөврийн усны алдагдлын нөхвөр | 60,0 | 30,0 | 30,0 | 15,0 | 0,0 |
| | Үйл ажиллагааны бус орлогын дүн | 283,2 | 97,3 | 149,0 | 66,0 | 97,6 |
| | Орлогын нийт дүн | 2559,1 | 2390,3 | 2395,6 | 2266,8 | 2357,4 |

Эх сурвалж: "Дорнод НАА" ОНӨААТҮГ-ын ерөнхий журналд суурилав.

Нийт орлогын гүйцэтгэл 2017 онд төлөвлөгөөнөөс 0,2 хувиар давсан байна. Үүнд үйл ажиллагааны бус орлогын төлөвлөгөө 53,1 хувиар биелсэн нь нөлөөлсөн байна.

Үйл ажиллагааны орлого 2017 онд төлөвлөсөн хэмжээнээс 2,0 хувь, өмнөх оны гүйцэтгэлээс 0,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Аудитын явцад шалтгааныг судалж үзэхэд:

- Гэр хороололд цэвэр ус түгээх үйлчилгээ 32,7 хувиар буурсан харагдаж байгаа нь зөөврийн усны алдагдалд орон нутгаас олгосон татаасыг 2016 онд үйл ажиллагааны орлогод оруулж тайлагнасантай холбоотой байна.
- Шинээр 2017 онд 20 аж ахуйн нэгж, байгууллага хэрэглэгч болж нэмэгдсэн байхад аж ахуйн нэгжийн цэвэр ус түгээх үйлчилгээ өмнөх оноос 4,5 хувиар буурсан нь усны алдагдал их байгааг харуулж байна.

Хүснэгт №3 "Усны алдагдалын судалгаа"

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2018 оны эхний хагас жил | 2017 он | 2016 он |
|---|-----------------------------|--------------------|--------------------------|---------|---------|
| 1 | Олборлосон усны нийт хэмжээ | мян.м ³ | 603.3 | 1190.1 | 1406.9 |
| 2 | Борлуулсан ус | мян.м ³ | 329.9 | 621.9 | 618.8 |
| 3 | Усны алдагдал | мян.м ³ | 273.4 | 568.2 | 788.1 |

| | | | | | |
|---|-----------------|---|-----|-----|-----|
| 4 | Алдагдалын хувь | % | 45% | 48% | 56% |
|---|-----------------|---|-----|-----|-----|

Эх сурвалж: "Дорнод НАА" ОНӨААТҮГ-ын санхүү, эдийн засгийн үзүүлэлт, тайлан мэдээлэлд суурилав.

Усны алдагдалд дараах хүчин зүйлүүд нөлөөлж байна. Үүнд:

- Насжилт өндөртэй, ашиглалтын шаардлага хангахгүй болсон дамжуулах шугам сүлжээний гэмтэл, цооролтын байдал,
- Орон сууцны байруудад 2008-2009 онд суурилуулсан усны тоолууруудын ашиглалтын хугацаа дуусч эвдрэл гэмтэл ихэссэн,
- Байцаагч нар сар бүр усны хэрэглээг бодитоор тооцдоггүй,
- Мөн айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын зохисгүй хэрэглээ.

Тус байгууллага нь усны алдагдалыг илрүүлэх зорилгоор Ивээл хороолол, орон сууцны 10 дугаар байр, Бумбат хорооллын ерөнхий шугамын оруулгад усны тоолуур суурилуулан хянаж, аж ахуйн нэгж, байгууллагуудын шугам сүлжээнд ажлын хэсэг томилон жилд 2-оос доошгүй удаа үзлэг, шалгалт зохион байгуулдаг гэсэн тайлбарыг удирдлагын зүгээс өгсөн боловч ахицтай үр дүнд хүрэхгүй байна.

Усны алдагдлыг бууруулах зорилгоор тоолуургүй айл өрх, байгууллагыг тоолууржуулах, усны алдагдлыг багасгах талаар хяналтын шинэ систем хэрэгжүүлэх, ашиглалтын хугацаа дууссан, насжилт өндөртэй тоолуур, шугам хоолойнуудыг шинэчлэх, гүний худаг барих тооцоо судалгааг гаргаж, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө нөөцийг улс, орон нутгийн төсөвт суулган батлуулах, ажилтнуудын хариуцлагыг дээшлүүлэх талаар бодитой арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай байна.

Бүлэг 2.2. Төлөвлөсөн зардлыг нийт дүнгээр хэмнэсэн боловч арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зардлууд гарсан байна.

"Дорнод НАА" ОНӨААТҮГ нь 2017 онд нийт 2354,7 сая төгрөгийн зардалтай ажиллаж үндсэн үйл ажиллагаанд 2093,8 тэрбум төгрөг буюу нийт зардлын 88,9 хувийг, үндсэн бус үйл ажиллагаанд 125,4 сая төгрөг буюу 5,3 хувийг, удирдлагын зардалд 135,5 сая төгрөг буюу 5,8 хувийг тус тус зарцуулжээ.

Үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №4 “Зардлын судалгаа” /мян.төг/

| № | Үйл ажиллагааны зардал | 2017 он | | Өөрчлөлт | Эзлэх хувь |
|----|------------------------------|------------|-----------|----------|------------|
| | | төлөвлөгөө | гүйцэтгэл | | |
| 1 | Цалингийн зардал | 1030744,7 | 1029118,9 | -1625,8 | 49,2 |
| 2 | Ажил олгогчоос төлөх ЭМД НДШ | 123689,4 | 122628,7 | -1060,7 | 5,9 |
| 3 | Цахилгаан | 260583,2 | 240837,4 | -19745,8 | 11,5 |
| 4 | дулаан | 22135,3 | 19399,2 | -2736,1 | 0,9 |
| 5 | нүүрс | 11200,0 | 12457,2 | 1257,2 | 0,6 |
| 6 | шатахуун | 76716,8 | 77760,6 | 1043,8 | 3,7 |
| 7 | хөрөнгийн элэгдэл | 402742,7 | 399790 | -2952,7 | 19,1 |
| 8 | урсгал засвар | 100000,0 | 100127,8 | 127,8 | 4,8 |
| 9 | хөдөлмөр хамгаалал | 25000,0 | 19515,7 | -5484,3 | 0,9 |
| 10 | бичиг хэрэг | 1303,0 | 1498,4 | 195,4 | 0,1 |

| | | | | | |
|----|--------------------|------------------|------------------|-----------------|--------------|
| 11 | холбоо | 8285,4 | 5437,8 | -2847,6 | 0,3 |
| 12 | материал түүхий эд | 40000,0 | 21402,0 | -18598,0 | 1,0 |
| 13 | албан томилолт | 4675,5 | 4481,9 | 193,6 | 0,3 |
| 14 | бусад | 40000,0 | 33501,4 | -6498,6 | 1,6 |
| 15 | тээврийн зардал | 5614,4 | 5840,7 | 226,3 | 0,3 |
| | ДҮН | 2152690,4 | 2093797,7 | -58892,7 | 100,0 |

Эх сурвалж: "Дорнод НАА" ОНӨААТҮГ-ын ерөнхий журналд суурилав.

Үйл ажиллагааны зардлын 49,2 хувийг цалингийн зардал, 19,1 хувийг элэгдлийн зардал, бусад зардлууд 31,7 хувийг тус тус эзэлж байна.

Нийт дүнгээрээ үйл ажиллагааны зардал төлөвлөсөн хэмжээнээс 2,7 хувиар хэмнэгдсэн боловч хэтэрсэн зардлууд байна. Шалтгааныг шинжилж үзэхэд шатахуун, нүүрсний зардал 1,0-1,2 сая төгрөгөөр хэтэрсэн нь үнэ өссөнтэй холбоотой байна.

Үйл ажиллагааны бус зардал

Хүснэгт №5 “Зардлын судалгаа” /мян.төг/

| № | Үйл ажиллагааны бус зардал | 2017 он | | Өөрчлөлт | Эзлэх хувь |
|----|-----------------------------------|-----------------|-----------------|---------------|--------------|
| | | төлөвлөгөө | гүйцэтгэл | | |
| 1 | буцалтгүй тусламж | 3500,0 | 2920,0 | -580,0 | 2,3 |
| 2 | ахмадын сан | 10000,0 | 9762,9 | -237,1 | 7,8 |
| 3 | шагнал урамшуулал | 4000,0 | 3636,2 | -363,8 | 2,9 |
| 4 | тэтгэмж | 22732,7 | 20825,6 | -1907,1 | 16,6 |
| 5 | зар сурталчилгаа | 2000,0 | 2387,6 | 387,6 | 1,9 |
| 6 | тусгай зөвшөөрлийн хураамж | 0,0 | 2000,0 | 2000,0 | 1,6 |
| 7 | гадаад үйл ажиллагаа | 8000,0 | 8168,5 | 168,5 | 6,5 |
| 8 | санхүүгийн программ хангамж | 0,0 | 1550,0 | 1550,0 | 1,2 |
| 9 | сургалт | 1500,0 | 1508,8 | 8,8 | 1,2 |
| 10 | спорт, наадмын арга хэмжээ | 3500,0 | 5916,2 | 2416,2 | 4,7 |
| 11 | аудитын хөлс | 2000,0 | 0,0 | -2000,0 | 0,0 |
| 12 | бусад | 51414,2 | 56121,9 | 4707,7 | 44,7 |
| 13 | ажлын хөлсний урамшуулал | 1200,0 | 1638,3 | 438,3 | 1,3 |
| 14 | үндсэн хөрөнгө ашиглалтаас хассан | 0,0 | 255,0 | 255,0 | 0,2 |
| 15 | зохицуулалтын үйлчилгээний хөлс | 9500,0 | 8705,5 | -794,5 | 6,9 |
| 16 | тендрийн ажлын зардал | 0,0 | 0,0 | 0,0 | 0,0 |
| | ДҮН | 119346,9 | 125396,5 | 6049,6 | 100,0 |

Эх сурвалж: "Дорнод НАА" ОНӨААТҮГ-ын ерөнхий журнал.

Үйл ажиллагааны бус зардал батлагдсан төсвөөс 5,1 хувиар хэтэрсэн байна. Спорт, бүсийн уулзалтын арга хэмжээний зардал 69,0 хувь, ажлын хөлсний урамшуулал 36,5 хувь, бусад зардал 9,2 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хэтрэлтэд төлөвлөгөөнд тусгагдаагүй төлөвлөх боломжгүй үндсэн хөрөнгө ашиглалтаас хассан, санхүүгийн программ хангамжийг засварласан зэрэг нь нөлөөлсөн ч төлөвлөх боломжтой тусгай зөвшөөрлийн хураамжийн зардлыг төлөвлөөгүй байна.

Аудитын явцад зардал хэтэрсэн шалтгааныг шинжилж үзэхэд дараах байдалтай байна.

- Ажлын хөлсний урамшуулалын зардал хэтэрсэн нь гадагш гүйцэтгэсэн техникийн үйлчилгээ нэмэгдсэн,
- Спорт, бүсийн уулзалтын арга хэмжээний зардал хэтэрсэн нь 3 удаагийн зүүн бүсийн зөвлөгөөн, урлаг наадам, спортын тэмцээн болсон,
- Бусад зардал хэтэрсэн нь ТУЗ-ийн тогтоолоор урамшууллын хэмжээ нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

Монгол Улсын хэмжээнд хэмнэлтийн горимд сүүлийн жилүүдэд шилжин УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолыг баримтлан ажиллаж байхад 2017 онд спортын арга хэмжээ, бүсийн уулзалтад 5,9 сая төгрөг, гадаад сургалт 8,2 сая төгрөг, аймгийн цэнгэлдэх хүрээлэнгийн засварт 1,5 сая төгрөг, 2018 онд спортын арга хэмжээнд 5,1 сая төгрөг, урлагийн наадамд 3,8 сая төгрөг, гадаад аялалд 4,5 сая төгрөгийг байгууллагын төсвөөс санхүүжүүлсэн байна.

ТУЗ-ийн тогтоолоор 2016 оны цэвэр ашгийн 30,0 хувь буюу 24,6 сая төгрөг, 2017 оны цэвэр ашгийн 30,0 хувь буюу 11,1 сая төгрөг нийт 35,7 сая төгрөгийг гүйцэтгэх захиралд олгосон нь ТУЗ-ийн гүйцэтгэх захиралтай байгуулсан хариуцлагын гэрээний 1.5 дахь “Энэхүү гэрээ нь менежментийн гэрээний биелэлтийг хангах, удирдлагын эрх зүйг тодорхойлсон баримт болно”, 7.3 дахь “Аймгийн Засаг даргатай байгуулсан менежментийн гэрээний заалтын биелэлтийг үндэслэн урамшууллын хэмжээг тогтооно”, “Дорнод НАА” ХХК-ийн дүрмийн 1.3 дахь Компанийн үүсгэн байгуулагч өмчлөгч нь Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуульд заасны дагуу Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга байна, 5.1 дэх Компанийн удирдлага дараах бүтэцтэй байна. Үүнд: 5.1.1 Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, 8.2 дахь “Гүйцэтгэх захирал нь аймгийн Засаг дарга, ТУЗ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд аймгийн Засаг дарга, ТУЗ-ийг төлөөлж түүний дарга нарын гарын үсэг зурна. Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ нь арилжааны 5 банкинд данстай боловч 2017 онд 200,6 сая төгрөг, 2018 онд 102,2 сая төгрөгийн зардлыг кассаар бэлнээр зарцуулсан байна.

Хүснэгт №6 “2015-2018 онуудын ашиг, алдагдлын судалгаа” /сая.төг/

| Үзүүлэлтүүд | 2018 оны эхний хагас жил | | 2017 он | | 2016 он | | 2015 он | |
|-----------------------|--------------------------|--------|---------|------|---------|------|---------|-------|
| | төлөв | гүйц | төлөв | гүйц | төлөв | гүйц | төлөв | гүйц |
| Цэвэр ашиг /алдагдал/ | -215,5 | -111,7 | -21,3 | 36,8 | -78,3 | 82,2 | -221,3 | 122,7 |

Эх сурвалж: “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан.

Дээрх хүснэгт №5-т үзүүлсэн байгууллагын цэвэр ашгийн үзүүлэлтээр сүүлийн 3 жил алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр ашигтай ажиллаж ирсэн нь төлөвлөлт үндэслэлтэй хийгдэхгүй байгааг харуулж байна.

Харин 2018 оны хагас жилийн санхүүгийн тайлангаар 111,7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үүнд Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 38 тоот шийтгэх тогтоол, Дорнод аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалын 2017 оны 26 тоот тогтоол, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2017 оны 215 дугаар

тогтоолуудын дагуу Монгол Улсын нэрийн өмнөөс иргэний хариуцагч “Дорнод Нийтийн Аж Ахуй” ОНӨААТҮГ-аас бусдын эрүүл мэндэд учирсан гэм хорын болон оршуулгын 146,8 сая төгрөгийн зардлыг төлүүлэхээр шийдвэрлэсэний дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд төлсөн зардал нөлөөлжээ.

2.3. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас авах он дамжсан авлагыг барагдуулж ажиллаагүй байна.

"Дорнод НАА" ОНӨААТҮГ-ын нийт авлага 2016 оны эцэст 378,5 сая төгрөг байсан бол 2017 оны оноос авлага барагдуулах урамшууллын журам гарган мөрдөж ажиллан 35,3 сая төгрөгөөр бууруулсан ч 2018 оны эхний хагас жилийн байдлаар 463,4 сая төгрөг болж 120,2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 “Авлага, өглөгийн гүйцэтгэл” /сая.төг/

| Үзүүлэлтүүд | 2018 оны эхний хагас жил | 2017 оны жилийн эцэс | 2016 оны жилийн эцэс |
|---------------------------|--------------------------|----------------------|----------------------|
| Дансны авлага | 446,3 | 339,4 | 374,6 |
| Бусад авлага | 17,1 | 3,8 | 3,9 |
| Нийт авлага | 463,4 | 343,2 | 378,5 |
| Богино хугацаат өр төлбөр | 24,2 | 16,9 | 10,1 |
| Урт хугацаат өр төлбөр | 3254,0 | 3254,0 | 3254,0 |
| Нийт өр төлбөр | 3278,2 | 3270,9 | 3264,1 |

Эх сурвалж: "Дорнод НАА" ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан.

Айл, өрхөөс авах усны авлага 2017 онд нийт авлагын 72,2 хувь буюу 245,3 сая төгрөг байсан бол 2018 оны эхний хагас жилд нийт авлагын 73,3 хувь буюу 327,2 хувь болсон байна.

2017 оны эхний улиралд 8 айл өрхийн 4,9 сая төгрөгийг шүүхэд шилжүүлж бүрэн барагдуулсан бол 2018 оны эхний улиралд 18 айл өрхийн 8,7 сая төгрөгийг шүүхэд шилжүүлж ажилласан боловч одоог хүртэл бүрэн шийдвэрлэгдээгүй, 2018 оны 6 дугаар сараас эхлэн өр төлбөртэй айл өрхүүдэд мэдэгдэл тараан ажиллаж байгаа гэсэн мэдээлэл өгсөн ч гүйцэтгэл нь хангалтгүй, авлага буураагүй байна.

Аж ахуйн нэгж, байгууллагаас авах усны авлага 2017 онд нийт авлагын 12,4 хувь буюу 42,0 сая төгрөг байсан бол 2018 оны эхний хагас жилд нийт авлагын 11,9 хувь буюу 53,1 сая төгрөг болсон байна.

Он дамжиж 2016-2017 онуудад үүссэн үйл ажиллагаа явуулж байгаа 17 аж ахуйн нэгж, байгууллагаас авах усны 18,6 сая төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй байна.

Богино хугацаат өр төлбөр 2016 оны эцэст 10,1 сая төгрөг, 2017 онд 16,9 сая төгрөг, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 24,2 сая болж нэмэгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөрийг судлан шинжлэхэд 2018 оны эхний хагас жилийн байдлаар дансны өглөг 15,4 сая төгрөг, татварын өглөг 8,8 сая төгрөг байна. Татварын өглөг дараа сардаа төлөгдөхөөр байна. Нийт дансны өглөгийн 74,0 хувь буюу 11,4 сая төгрөгийн өглөг нь албан байгууллага, айл өрхийн илүү төлөлттэй, хаяг нь тодорхойгүй усны төлбөр байна.

Бүлэг III. Хөрөнгийн худалдан авалт хууль, журмын дагуу явагдаагүй байна.

3.1. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ нь 2017 онд 9, 2018 онд 7 бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө баталсан байна.

Үүнээс 18,0 сая төгрөгийн 1 бараа нийлүүлэх тендерт худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 13,7 сая төгрөгөөр БНХАУ-аас шууд худалдан авалт хийсэн байна.

Хуулийн дагуу тендер амжилтгүй болсон 30,0 сая төгрөгийн бараанд шууд гэрээ байгуулж ажилласан ч ингэхдээ гэрээний хувийг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34.3 дахь заалтын дагуу Сангийн Яаманд хүргүүлээгүй байна.

Шууд гэрээ байгуулсан БЭЗҮ ХХК-ийн ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 14-16 дугаар зүйлийн шалгуур хангасан этгээд эсэх нь нотлогдохгүй байна. /ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34.2 дахь заалт/

Тэвштэй кран худалдан авах 60,0 сая төгрөгийн төсөвтэй бараа нийлүүлэх нээлттэй тендерийг Орон нутгийн өмчийн газарт 2 удаа зарлаад амжилтгүй болж “Дорнод НАА” ОНӨААТҮГ-т шууд гэрээ байгуулж ажиллах зөвлөмж өгсөн байна. “Дорнод НАА” ОНӨААТҮГ нь харьцуулалтын аргаар дахин зарлаж “Дорнын үндэс” ХХК-тай гэрээ байгуулан авсан 59,5 сая төгрөгийн үнэтэй автомашин нь зах зээлийн ханшнаас өндөр дүнтэй байна. Зарын хамгийн том цахим сайтад www.unegui.mn/ ижил төстэй он залуу тэвштэй кранууд 20-52 сая төгрөгийн үнэтэй зарагдаж байна.

Уг тэвштэй краны техникийн тодорхойлолтыг 3 удаа өөрчилсөн бөгөөд нээлттэй тендер шалгаруулалтын анхны техникийн тодорхойлолтод “2017 оноос хойш үйлдвэрлэгдсэн, 2018 оны 1 дүгээр улиралд Монгол улсад орж ирсэн, өмнө нь ашиглаж байгаагүй, шинэ байх бөгөөд км-ын гүйлт нь ачилт буулгалтын явсан зайнаас хэтрэхгүй” гэсэн өндөр шаардлага тавьж өгсөн нь өрсөлдөөнийг хязгаарлах улмаар нээлттэй тендерийг амжилтгүй болгох нөхцөл үүсгэсэн байна. Гэвч гэрээ байгуулж худалдан авсан техникийн үзүүлэлт нь 1995 онд үйлдвэрлэгдсэн, 2012 онд Монгол улсад орж ирсэн, 200,0 мянган км гүйлттэй гэх мэт хуучирсан үзүүлэлттэй байна.

Дээрх төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авалтуудаас гадна гүйцэтгэх захирал болон бараа материалын нярав, нягтлангууд Улаанбаатар хотод томилолтоор ажиллахдаа 2017 онд 3 удаагийн 59,3 сая, 2018 оны хагас жилийн байдлаар 1 удаагийн 42,7 сая төгрөгийн сэлбэг болон материалын шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.2.”шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-аас давсан байна.

Бүлэг 3.2. “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн худалдан авалтын төлөвлөгөө боловсруулсан эсэх нь тодорхойгүй байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын хөрөнгийн худалдан авалтыг төлөвлөхдөө нэгжүүдээс шаардлагатай болон эвдрэл гэмтэлтэй байгаа хөрөнгийн саналуудыг авч нэгтгэн эрэмбэлэн гүйцэтгэх захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн худалдан авалтын төлөвлөгөөний төслийг ТУЗ-ийн хурлаар оруулж батлуулдаг байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах хөрөнгийн саналыг 2017 онд нэгжүүдээс авч, хэлэлцсэн, эрэмбэлсэн хурлын протокол ажлын баримт хангалтгүй байна.

Харин 2018 онд 7 төсөл арга хэмжээ батлахдаа нэгжүүдээс авсан саналыг үндэслэн 2017.12.05-ны өдрийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ нь 2017 онд худалдан авалтын төлөвлөгөөндөө ухаалаг ус түгээх байр 2 ширхэгийг байгуулах ажлыг цуцалж 2 автомашины мотор солих болгож өөрчлөлт оруулсан байна. Мөн тус онд архивын программ, нягтруулсан шүүгээ шинэчлэх ажил хэрэгжээгүй байна. Энэ нь уг худалдан авах барааны үнэ

болоод бэлтгэн нийлүүлэгчийн талаар судалгаа шинжилгээг хангалтгүй хийсэнтэй холбоотой байна.

3.3. Хөрөнгийн ашиглалт үр дүнтэй байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын 2017, 2018 онуудад худалдан авсан хөрөнгийг үзэж, ашиглалтын байдалтай танилцахад хэвийн ажиллагаатай байна.

Аудитын хамрах хугацаанд хийгдсэн бараа, ажлуудын ашиглалтын талаар санал, гомдол гарч нийлүүлэгч, гүйцэтгэгчтэй харьцсан тохиолдол гараагүй байна.


Харин 2007 онд Барилга, Хот байгуулалтын Яамнаас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 139,0 сая төгрөгийн үнэтэй Бульдозер маркийн хүнд машин механизм нь тухайн ондоо эвдэрч одоог хүртэл ашиглагдаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын бүтэц, зохион байгуулалт болон орон нутгийн удирдлагаас тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
2. “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын ТУЗ-д хараат бус гишүүн байхгүй байна.
3. Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, дүгнүүлээгүй байхад ТУЗ-өөс үйл ажиллагааг нь хангалттай гэж дүгнэж Гүйцэтгэх захиралд урамшуулал олгосон байна.
4. “Дорнод НАА” ОНӨААТҮГ нь орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, арвилан хэмнэлтгүй зардлууд гаргасан байна.
5. Хөрөнгийн худалдан авалт хууль, журмын дагуу явагдаагүй байна.

Аудитаар нийт 427,9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 54,3 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 205,6 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 7 зөвлөмж өгч ажиллалаа.



Саналд өгөх тайлбар:

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-аас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

Тайлбар 2.2-т ТУЗ-ийн гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний 7.1, 7.2 дахь заалтыг мөрдлөг болгон урамшуулал олгосон, 7.3 дахь заалтад урамшууллыг хэмжээг тогтооно гэж заасан нь энэ нь тус гэрээний 2.7 дахь заалтад заасан 10.0-30.0 хувийг тогтооно гэсэн ойлголт бөгөөд урамшуулал олгох, эс олгохыг уг гэрээний 7.3 дахь заалтад заагаагүй гэж үзэж, уг гэрээний заалтыг тодруулж Засаг даргаар нэг бүрчлэн дүгнүүлснээр ТУЗ-өөр хэлэлцүүлж ажиллах болно. Иймд Гүйцэтгэх захиралд олгосон 35,7 сая төгрөгийн урамшуулалд тогтоосон төлбөрийн актыг зөвлөмж болгон дүгнэлт гаргаж өгөхийг хүссэн байна.

ТУЗ-ийн гүйцэтгэх захиралтай байгуулсан хариуцлагын гэрээний 1.5-д “Энэхүү гэрээ нь менежментийн гэрээний биелэлтийг хангах, удирдлагын эрх зүйг тодорхойлсон баримт болно” гэсэн нь энэ гэрээ өөрөө менежментийн гэрээг байгуулсан нөхцөлд үйлчилнэ гэсэн заалт болно. Иймд аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, дүгнүүлсэн тохиолдолд л уг гэрээнд тусгагдсан гэрээний биелэлт тооцох, урамшуулал олгох болон урамшууллын хэмжээг тогтоох тухай заалтуудыг үндэслэн урамшуулал олгох тул тус саналын дагуу аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Мөн 1-2 гүний худаг зайлшгүй шаардлагатай тул зөвлөмжид тусгаж өгөхийг хүссэн байна.

Ашиглалтын хугацаа дууссан, насжилт өндөртэй тоолуур, шугам хоолойнуудыг шинэчлэх, гүний худаг барих тооцоо судалгааг гаргаж, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө нөөцийг улс, орон нутгийн төсөвт суулган таслуулах талаар бодитой арга хэмжээ зохион байгуулах талаар тайланд тусгасан тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Хишигтогтоход:

1. “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын ТУЗ-ийн гишүүдийг томилохдоо хуулийн үндэслэлтэй мөн хуульд заасан гишүүдийн тоо болон хараат бус гишүүдийг хуулийн дагуу томилох.

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд:

1. “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын Гүйцэтгэх захиралтай менежментийн гэрээг байгуулж, дүгнэж ажиллах.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. ТУЗ нь үйл ажиллагаандаа хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэн, “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх, өртөг зардлыг багасгах, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэхэд анхаарч ажиллах.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал Г.Баярсайханд:

1. Зохион байгуулалтын бүтцийг ТУЗ-ийн баталсан бүтэц, орон тоотой уялдуулж, хүний нөөцийн бодлого боловсруулан ажиллах.
2. Орон нутгийн удирдлагатай гэрээ байгуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах.
3. Орлогыг үндэслэлтэй төлөвлөж, усны алдагдлыг бодитой бууруулж зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх.
4. Хөрөнгийн худалдан авалтыг хууль, журмын дагуу явуулж байх.

SEPTEMBER 28, 2018

“ДОРНОД НАА” ОНӨААТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Аудитаар тавигдсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2019 оны 03 дугаар сарын 30-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
УЛААНБААТАР

Аймагын аудитын байр
Хөвсгөл сум

Төрийн аудитын газар 15.0 сая. төгрөг, Манж Улаан Говь суманд 100.0 сая. төгрөг тулалзы 3 дугаар хэсгийн 2.4 фш. амт 200 сая. төгрөг үзүүлж Төрийн “Дорнод аймаг” олон улсын улс дотоод хөрөнгийн үйлчилгээний үйлдвэр 2018 оны 03 сарын 30-ны өдөр төрийн аудитын үйлчилгээг үндэслэн ТЭГЭМЭЭ нь

1. Дорнод аймаг “СЭВЭЛТ” үн. хх. аагийнхны 19.0% хэсэг хөрөнгийн хэсгийн үйлчилгээний байрныг
2. Хөвсгөл сум, төрийн үн. хх. аагийнхны хөрөнгийн хэсгийн 3. Аймаг, манж улсын өмчлөлийн Төрийн аудитын байрны үйлчилгээний байр 2018 оны 03 сарын 30-ны өдөр төрийн аудитын үйлчилгээний үйлдвэр 2018 оны 03 сарын 30-ны өдөр төрийн аудитын үйлчилгээний үйлдвэр 2018 оны 03 сарын 30-ны өдөр төрийн аудитын үйлчилгээний үйлдвэр
4. Төрийн аудитын газар 15.0 сая. төгрөг, Манж Улаан Говь суманд 100.0 сая. төгрөг тулалзы 3 дугаар хэсгийн 2.4 фш. амт 200 сая. төгрөг үзүүлж Төрийн “Дорнод аймаг” олон улсын улс дотоод хөрөнгийн үйлчилгээний үйлдвэр 2018 оны 03 сарын 30-ны өдөр төрийн аудитын үйлчилгээний үйлдвэр

УЛААНБААТАР
“ТӨРИЙН АУДИТ”



Төрийн аудитын үйлчилгээний үйлдвэр

| № | Аймаг, манж улсын өмчлөлийн үйлчилгээний байр | Төрийн аудитын газар | Төрийн аудитын газар |
|---------|--|----------------------|----------------------|
| 1 | Дорнод аймаг “СЭВЭЛТ” үн. хх. аагийнхны 19.0% хэсэг хөрөнгийн хэсгийн үйлчилгээний байрныг | 2018-03-30 | 2018-03-30 |
| 2 | Дорнод аймаг “СЭВЭЛТ” үн. хх. аагийнхны 19.0% хэсэг хөрөнгийн хэсгийн үйлчилгээний байрныг | 2018-03-30 | 2018-03-30 |
| ТЭГЭМЭЭ | | | 2018-03-30 |

Аймаг, манж улсын өмчлөлийн үйлчилгээний байр

| № | Аймаг, манж улсын өмчлөлийн үйлчилгээний байр | Төрийн аудитын газар | Төрийн аудитын газар |
|---------|--|----------------------|----------------------|
| 1 | Дорнод аймаг “СЭВЭЛТ” үн. хх. аагийнхны 19.0% хэсэг хөрөнгийн хэсгийн үйлчилгээний байрныг | 2018-03-30 | 2018-03-30 |
| ТЭГЭМЭЭ | | | 2018-03-30 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ӨЗГӨӨЛӨХ АУДИТОР
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ
В.ЦЭНГЭЛМАА
Б.ДЭЛГЭРМАА
М.УХААНБИЛЭГ
Я.ЗОРИГ

БИЧСЭН:
2117144000

